



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 03 өдөр

Дугаар А/88

Мандалговь

Аймгийн Соёлын өвийн бүртгэл,
мэдээллийн санг шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5(а), Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Боловсрол, соёл урлагийн газарт бүрдүүлсэн Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санг орон нутгийн Музейд шилжүүлсүгэй.

Хоёр. Аймгийн Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд тухайн нутаг дэвсгэрт орших соёлын өвийг бүртгэн, цуглуулах, хадгалж хамгаалах, судлан, сурталчлах ажлыг хариуцах орон тоог бий болгон, тус албан тушаалтныг томилон ажиллуулахыг аймгийн Музей (М.Бямбажав)-д үүрэг болгосугай.

Гурав. Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн бүртгэл, бүрдүүлэлт, ашиглалт, хадгалалт хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг аймгийн Боловсрол, соёл урлагийн газар (Ц.Бумангэрэл)-т даалгасугай.

Дөрөв. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 1999 оны 1 дүгээр сарын 27-ны 15 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

482010267